Төр оршихуй дор татвар оршдог. Оороор хэлбэл иргэн хvн тордоо татвар толох vvрэгтэй. Тиймээс ч бид энэхvv vvргээ хэлбэрэлтгvй биелvvлсээр ирсэн. Ганц нэг хумсаа нуусан нохдvvдийг эс тооцвол.

Харин тор засаг маань ард тvмнийхээ толсон татварын хоронгийг хий хоосон vр дvнгvй зvйл зарцуулан эрх мэдэл сандайлсан хэсэг бvлэг хvний гарын салаагаар урсгаснаас улс орны эдийн засаг туйлдаад буйг нуух юун.

Тодруулбал энэ оны улсын тосвийн орлогоос 1.5 их наяд тогрог сох дутсан. Yvнээс эхний хагас жилийн гvйцэтгэлээр татварын орлого 200 тэрбумаар тасраад буй. Ногоотэйгvvр энэ бvгд гадны хоронго оруулагчдын итгэл алдарч хоронго оруулалттай татсантай ч холбоотой.

Тиймээс онгорогч одрvvдэд УИХ-аар Монголд хөрөнгө оруулалт татах зорилго бvхий Хөрөнгө оруулалтын тухай болон Хөрөнгө оруулатлтын сангийн тухай хуулийг бусад дагалдах хуулиудын хамтаар батлаад буй. Гэтэл энэхvv Хөрөнгө оруулалтын хуулийн малгайн дор татварын шинэ хуулиудыг нууж донгосноор ирэх оноос бид 17 нэр төрлийн шинэ татварыг төлж магадгvй болоод байна.

Уг нь бид эдийн засаг хvндрэлтэй байгаа энэ vедээ гадаадын хөрөнгө оруулалт хэмээн туйлширхаас илvvтэйгээр vндэсний vйлдвэрлэлээ дэмжин өөрсдийн гараар баялаг бvтээх учиртай. Гэтэл хvндрээд буй эдийн засгаа сэхээхийн тулд ард тvмнээсээ албадан татвар авах замаар төсвөө нэмэгдvvлэх нь. Тиймээс энэ бvхнийг тодруулбал:

1. “Хотын татвар”. Нийслэл хотод амьдарч байгаа хэн бvхэн, vйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж бvрээс энэхvv татварыг авахаар хуулийн төсөл боловсруулагдаж байгаа. Ингэснээрээ тэд Улаанбаатар хотын хэт төвлөрөлтийг сааргмагжуулж, багасгаж донгоно гэж vзэж байгаа. Гэсэн ч бvх vйлчилгээнээс татвар суутгана гэвэл татвар шингэсэн vнээр бараагаа борлуулах vйлдвэрлэгчдийг тор захиалан vнэ өсгөх гажиг тогтолцоог бvдvvлж мэднэ.

2. Аймгуудын татвар”. Бvх аймгийн тов болон улсын чанартай хотод ажиллаж амьдарч байгаа иргэдээс татвар авахаар хуулийн тосол бэлэн болгов. Бас л товлорлийг бууруулах, орон нутгийн хогжлийг дэмжих гэсэн vндсэн зорилготой.

3. “Үйлчилгээний татвар”. Энэ нь дээр хоёр татварын нэг хэсэг богоод хязгаарлалтай. Тухайлбал аймаг, нийслэлийн аль нэгэн газар vйлчилгээ явуулсан тохиолдолд татвар толно гэсэн vг. Ингэхдээ vйлчилгээ авсан vнийн дvн дээрээ татвартай газраар vйлчлvvлсэнийхээ толоо “vйлчилгээний татвар” нэмж толно гэсэн толгой эргvvлэм хувилбар.

4. “Ов хоронгийн татвар”. Үр хvvхдvvддээ овлvvлэн vлдээж байгаа vл ходлох болон ходлох хоронгоноос татвар авахаар бэлтг эжээ. Гэхдээ энэ торлийн татвар нэлээд олон торолтэй байж болохыг势 сануулсан.

5. “Бэлэглэлийн татвар”. Иргэд хоорондоо vл ходлох хоронгийг худалдахдаа бэлэглэлийн гэрээ хийж улсад нэг ч торлийн татвар толдоггvй
нь буруу зvйл гэж vзжээ. Тиймээс бэлэглэлийн татварыг бий болгох аж.

6. “Бэлгийн малын татвар”. Энэ нь инээдтэй богоод басхvv сонирхолтой. Хэн нэгэн хvvхэддээ халзан цагаан хонь бэлэглэхдээ татвар толно. Хэрэгжvvлхэд ихээхэн товогтэй богоод хэл ам дагуулж мэдэх ийм л зvйлийг шударга ёсонд нийцнэ гэж засаг vзэв.

7. “Үнэт эдлэлийн татвар” vнэт эдлэлээ vр хvvхэддээ овлvvлэн vлдээсэн ч гэсэн татвар авах нь .

8. “Бэлэн монгоний татвар” vр хvvхэддээ бэлэн монго овлvvлж vлдээхээс ч улс хувь хишигээ ав на.

9. Хувь хvний орлогын албан татвар” Хувь хvний орлогын одоогийн албан татвар Монголд хувь хvний нийт орлогын 5-8 хувьтай байдаг нь хэтэрхий бага гэж vзэж байгаа богоод дэлхийн жишгээр энэ 30 хувьтай байдаг аж.

10. “Малчдын татвар” Малчин орх, мал бvхий этгээдийн мал бvрээс татвар авах гэнэ. Ин гэхдээ малын тоог нэг хонины толгойгоор бодож тооцох аж. Харин vхсэн, алдсан малыг гамшгийн улмаас хорогдсон нотлох баримтыг vндэслэж татвараас хасч тооцох аж.

11. “Утаа хаядаг машины татвар”. Нэг километр зайд явахад 120 грамм болон тvvнээс их хэмжээний нvvрс хvчлийн хий ялгаруулдаг авто тээврийн хэрэгслээс авна.

12. “Азын дугаарын татвар” Азын болон монгон улсын дугаар хэрэглэж байгаа автомашины эзнээс татвар авдаг болно. Эсвэл ийм торлийн улсын дугаарыг дуудлага худалдаанд оруулж тосовт монго товлорvvлнэ .

13. “Нийтийн зогсоолын татвар”. Улаанбаатар дахь нийтийн зогсоолуудаас татвар авна.

14. “Байгалийн бохирдлын татвар”. Нийслэлд нvvрс тvлсэн айл орх, аж ахуйн нэгжvvдээс Улаанбаатарын агаарыг бохирдуулсан гэх vндэслэлээр ихээхэн хэмжээний татвар ав на. Хэрэв энэ тохиолдолд гэр хорооллын айл орх бvр энэхvv татварыг толох нь зайлшгvй.

15. “Хог хаясны татвар”. Хог хаясны хураамжийг нэмэгдvvлэхээр хуулийн тослvvдэд тусга жээ.

16. “Гол ус бохирдуулсаны татвар” Туул голруу бохироо асгадаг арьс ширний vйлдвэрvvд, голд машинаа угаасан этгээдvvдийг журамлахад энэ хууль хэрэг болох нь гарцаагvй басхvv зайлшгvй.

17. “Hvvрс олборлолтын татвар”. Hvvрс агаарыг ихээр бохирдуулдаг тул тvvхий нvvрс олборлодог аж ахуйн нэгжээс килограммаар нь тооцож татвар ав
ах гэнэ
.

Мэдээж хууль хэрэгжээд эхэлсэн даруйд бид толох vvрэгтэй ч толох нь битгий хэл уншихаас ч инээд хvрэм адал сонин татварууд шинээр бий болох нь. Энэ тохиолдолд бид эдгээр 17 татварыг толох нь шударга ёсонд хэр нийцэх вэ? Таны бодол.

(Эх сурвалж Undesten.mn)